



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Ажилчдын болон хүүхэд тээвэрлэх
автобусыг бүртгэх журмыг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, Замын хөдөлгөөний дүрмийн 11.10 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1037 дугаар захирамж, 2022 оны А/88 дугаар захирамжаар батлагдсан Нийтийн тээврийн газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажилчдын болон хүүхэд тээвэрлэх автобусыг бүртгэх журам”-ыг нэгдүгээр, хүүхдийн автобусны зөвшөөрлийн загварыг хоёрдугаар, ажилчдын автобусны зөвшөөрлийн загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Ажилчдын болон хүүхэд тээвэрлэх автобусыг бүртгэж бүртгэлийн сан үүсгэх, зөвшөөрөл олгож, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр зорчих тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг холбогдох байгууллагуудад тухай бүр хүргүүлэн ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс (Б.Дөлгөөн)-т, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Мягмар)-т, автобусыг тогтоосон хугацаанд техникийн хяналтын үзлэгт оруулах ажлыг хуваарийн дагуу зохион байгуулахыг Техник технологийн хэлтэс (Б.Мөнхболд)-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Нийтийн Тээврийн үйлчилгээний газрын даргын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/69 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.


ДАРГА

С.ЖАВХЛАНТБААТАР



. 1150500792

Нийтийн тээврийн газрын даргын
2023 оны 2 дүгээр сарын 17-ны
өдрийн 17 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



АЖИЛЧДЫН БОЛОН ХҮҮХЭД ТЭЭВЭРЛЭХ АВТОБУСЫГ БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь ажилчдын болон хүүхэд тээвэрлэх автобусанд Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргах, бүртгэлийн санд бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, мэдээллийг эрх бүхий байгууллагад хүргүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгч болон эрх бүхий бусад байгууллагатай хүүхэд болон ажилчид тээвэрлэх гэрээ байгуулсан байна.

1.3. Тээвэрлүүлэгч нь авто замын зорчих хэсгийн чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, автотээврийн хэрэгслийн улсын дугаарын сүүлчийн тоогоор ялган замын хөдөлгөөнд оролцуулахыг хязгаарласан авто замаар хүүхэд болон ажилчид тээвэрлэж, зорчих хүсэлтээ "Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээ" www.smartcar.mn сайтаар холбогдох баримт бичгийг pdf файл болгосон хавсралтын хамт Нийтийн Тээврийн газарт цахимаар ирүүлнэ.

1.4. Цахимаар ирүүлсэн хүсэлтийн дагуу Автотээврийн хяналтын улсын байцаагч "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага" MNS 4598:2011, "Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага" MNS 6440:2014 стандарт, Хотын стандарт "Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ, автобусанд тавигдах ерөнхий шаардлага" UCS 1604B:2022 болон бусад эрх зүйн бичиг баримтын хүрээнд автотээврийн хэрэгслийн техникийн байдлын дүгнэлтийг ажлын 10 хоногийн дотор гаргана.

1.5. Нийтийн Тээврийн газрын Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тус газрын Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс автотээврийн хэрэгслийг бүртгэлийн санд бүртгэж, автобусны улсын дугаарыг Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний Удирдлагын төвд цахимаар хүргүүлнэ.

Хоёр. Бүрдүүлэх баримт бичиг

2.1. Автотээврийн хэрэгсэл болон жолоочийг бүртгэлийн санд шинээр бүртгэхдээ www.smartcar.mn сайтаар ирүүлсэн дараахь баримт бичгийг үндэслэнэ. Үүнд:

2.1.1. Ажилчдын болон хүүхдийн автобусыг чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр улсын дугаарын хязгаарлалтгүйгээр зорчуулах тухай албан хүсэлт /pdf файл/;

2.1.2. Тээвэрлэгчтэй хийсэн хүүхэд болон ажилчид тээвэрлэх гэрээний хуулбар /pdf файл/;

2.1.3. Жолоочийн болон мэргэшсэн жолоочийн үнэмлэхний хуулбар /pdf файл/;

2.1.4.Автотээврийн хэрэгслийн гэрчилгээ болон жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний хуулбар /pdf файл/;

2.1.5.“Хүүхдийн автобус”, “Ажилчдын автобус” бичээсийг нийтэд ил тод харагдахаар нааж, 4 талаас авсан фото зураг” /pdf файл/;

2.1.6.Үйлчилгээний тогтоосон замнал, цагийн хуваарь /pdf файл/;

2.1.7.Зураг болон pdf файлууд шаардлага хангасан байх;

Гурав. Тээврийн хэрэгслийг бүртгэх

3.1.Бүртгэлийн сан хариуцсан мэргэжилтэн www.smartcar.mn сайтаар ирүүлсэн хүсэлттэй танилцан, холбогдох баримт бичгийг шалгаж, ажлын 2 хоногийн дотор Хяналт шалгалтын хэлтэст шилжүүлнэ.

3.2.Автотээврийн хяналтын улсын байцаагч нь хүүхэд тээвэрлэх автобусыг хүүхдийн ая тухтай, аюул осолгүй зорчих нөхцөл бүрдсэн, техникийн хувьд “Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага” MNS 4598:2001, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын үзүүлэлт, Хотын стандарт “Хүүхэд тээвэрлэх үйлчилгээ, автобусанд тавигдах ерөнхий шаардлага” UCS 1604B:2022 шаардлагыг хангасан тээврийн хэрэгсэлд дүгнэлт гаргана.

3.3.Автотээврийн хяналтын улсын байцаагчийн гаргасан дүгнэлтийг үндэслэн бүртгэлийн сан хариуцсан мэргэжилтэн тээврийн хэрэгслийг бүртгэлийн санд бүртгэж, Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг pdf файл болгон www.smartcar.mn сайтруу оруулж, зөвшөөрлийг олгоно.

3.4.Зөвшөөрөл олгосон ажилчдын болон хүүхэд тээвэрлэх автобусны улсын дугаарыг Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний Удирдлагын төвд цахимаар хүргүүлнэ.

Дөрөв. Жолооч болон автобусыг бүртгэхээс татгалзах,
бүртгэлийн сангаас хасах

4.1.Дараахь тохиолдолд тээврийн хэрэгсэл болон жолоочийг бүртгэхээс татгалзана.

4.1.1.Хүсэлт гаргагч нь энэ журмын 2 дахь хэсэгт заасан баримт бичгийг бүрдүүлээгүй буюу хуурамчаар бүрдүүлсэн;

4.1.2.Автобус нь энэ журмын 3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаагүй;

4.1.3.Жолооч нь бүртгэлийн санд давхардсан;

4.2.Дараах тохиолдолд бүртгэлийн сангаас хасаж, чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээгээр улсын дугаарын хязгаарлалтгүй зорчих жагсаалтаас хасна.

4.2.1.Хүүхдийн автобус нь “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын 5.1.3-д заасны дагуу үйлдвэрлэгдсэнээс хойш 12-оос дээш жил ашигласан;

4.2.2. Техникийн хяналтын хавар, намрын үзлэгт хуваарьт хугацаанд давтан орж тэнцээгүй, тээврийн хэрэгслийн техникийн болон хэрэглээний стандартын үзүүлэлт, шаардлага “хангахгүй” дүгнэлт гарсан, эсхүл огт ороогүйг тодорхойлсон техникийн хяналтын үзлэгийн төвийн мэдээ, “Хүүхэд тээвэрлэх автобус. Автобус ба үйлчилгээнд тавих шаардлага” MNS 6440:2014 стандартын 6.1.1 дэх заалтыг хангаагүй хасагдсан тээврийн хэрэгслийг тус газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн;

4.2.3. Тээвэрлэлтэд тэнцэхгүй тухай Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;

4.2.4. Бүртгэлээс хасуулах тухай тээвэрлүүлэгч нь хүсэлт гаргасан;

Тав. Хяналт тавих болон журам зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх

5.1. Журмын хэрэгжилтэд Нийтийн тээврийн газар, Улаанбаатар хотын Замын хөдөлгөөний удирдлагын төв болон Тээврийн цагдаагийн албаны эрх бүхий албан тушаалтан хяналт тавьж ажиллана.

5.2. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулна.

Нийтийн тээврийн газрын даргын
2023 оны 09 дүгээр сарын 03-ны
өдрийн 7 дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт



САНАМЖ

Хүүхдийн автобусны үйлчилгээнд дараах шаардлагыг мөрдөж ажиллахыг жолооч танд сануулж байна.

- Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон замнал, зогсоол болон цагийн хуваарийн дагуу тээвэрлэлийг гүйцэтгэнэ
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, автобусны хурдыг цагт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.
- Тээвэрлэлтийн явцад сурагчдад зөвлөмж, зааварчилгаа өгөх, хяналт тавих, хүүхдэд туслах үүрэгтэй насанд хүрсэн нэг хүн ажиллана.
- Хөдөлгөөн эхлэхийн өмнө ажилчдад зөв суух, хамгаалах бүс бүслэх, хөдөлгөөн аюулгүй байдлыг сахих зааварчилгааг өгнө.
- Автобусаар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.
- Автобус бүрэн зогсооны дараа хүүхдүүдийг буулгаж, суулгаж хаалгаа гүйцэд хаасны дараа хөдөлгөөнийг эхлүүлнэ.
- Тээвэрлэгч нь холбогдох дүрэм журам, стандартыг зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН MNS 6440 : 2014 "ХҮҮХЭД ТЭЭВЭРЛЭХ АВТОБУС БА ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИХ ШААРДЛАГА" СТАНДАРТЫН ШААРДЛАГЫГ ХАНГАСАН БОЛНО.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР

ЗӨВШӨӨРӨЛ

ХҮҮХДИЙН АВТОБУС

ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

20 оны -р сарын -с

20 оны -р сарын


АВТОБУСНЫ
МАРК ӨНГӨ

УЛСЫН ДУГААР



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР

Нийтийн тээврийн газрын даргын
2023 оны 09 дүгээр сарын 14-ны
өдрийн 4 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



САНАМЖ

Ажилчдын автобусны үйлчилгээнд дараах шаардлагыг мөрдөж ажиллахыг жолооч танд сануулж байна.

-Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн гэрээгээр тогтоосон замнал, зогсоол болон цагийн хуваарийн дагуу тээвэрлэлийг гүйцэтгэнэ.

-Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, автобусны хурдыг цагт 50 км-ээс хэтрүүлэхгүйгээр хөдөлгөөнд оролцоно.

-Тээвэрлэлтийн явцад сурагчдад зөвлөмж, зааварчилгаа өгөх, хяналт тавих, хүүхдэд туслах үүрэгтэй насанд хүрсэн нэг хүн ажиллана.

-Хөдөлгөөн эхлэхийн өмнө ажилчдад зөв суух, хамгаалах бүс бүслэх, хөдөлгөөн аюулгүй байдлыг сахих зааварчилгааг өгнө.

-Автобусаар зөвхөн хүүхэд тээвэрлэнэ.

-Автобус бүрэн зогссоны дараа хүүхдүүдийг буулгаж, суулгаж хаалгаа гүйцэд хаасны дараа хөдөлгөөнийг эхлүүлнэ.

-Тээвэрлэгч нь холбогдох дүрэм журам, стандартыг зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээнэ.

НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР

ЗӨВШӨӨРӨЛ

АЖИЛЧДЫН АВТОБУС

ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

20 оны -р сарын -с

20 оны -р сарын

АВТОБУСНЫ
МАРК ӨНГӨ

УЛСЫН ДУГААР



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР